

# АЯЛАН ТОГЛОЛТЫН МЭДЭЭЛЭЛ

## Винд Симфони буюу Үлээвэр хөгжмийн Симфони

2015 оны 01-р сар

Бригама Янга их сургууль

Монгол, Өмнөд Солонгос, Япон

Холбоо барих: Урлагийн менежмент

(801) 422-3576

*perform@byu.edu*

ШУУД МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ

Америкийн хамгийн их аялан тоглолт хийсэн их сургуулийн концертийн хамтлаг Бригама Янга их сургуулийн Винд Симфони буюу Үлээвэр хөгжмийн Симфони 2015 оны 5-р сард ногоон дэлхийн нөгөө талд бас нэгэн аялан тоглолтоо хийхээр мордох гэж байна. Монгол, Өмнөд Солонгос, Япон орнуудаар аялан тоглохдоо Винд Симфони (болох газар)-т... (он сар өдөр)-нд... (цаг) цагаас модон үлээвэр хөгжмийн зэмсэг, гуулин хөгжим, цохилуур хөгжмийн зэмсгийн хүчирхэг нүргэлсэн дуугаар таны сэтгэлийг хөдөлгөн гайхшигт хөгжмийн аялгуугаар таныг ариусган уяраах гэж байна

5-р сарын 1-ээс эхлэн симфоны аялал тэдний хэзээ ч очиж байгаагүй Монгол орноос эхэлсэн 23 хоногийн аялан тоглолтоо эхэлнэ. Улаанбаатар хотод байх үедээ симфони Монгол улсад анх удаа тоглолт хийгээд үл барам энэхүү өнө их түүхт орны соёлын өвтэй анх удаа дотно танилцах юм. Дараа нь 5-р сарын 8-нд энэхүү хамтлаг Өмнөд Солонгос улс руу аялаж тэнд зургаа хоногийн турш аялан тоглолтыг хийнэ. Симфон 5-р сарын 23-нд гэртээ харихаас өмнө аялан тоглолтоо цааш үргэлжлүүлж дахин нэг 7 хоногийг Японы Фукуока, Токио, Нагоя, Осака хотуудад Японы улсыг хөндлөн гулд аялан тоглоно.

Доктор Дональд Петрийн удирдамжин дор Винд Симфонитус их сургуулийн анхны концертийн хамтлаг болох Винд Симфони нь модон үлээвэр хөгжмийн зэмсэг, гуулин хөгжим, цохилуур хөгжмийн зэмсэг тоглодог хамгийн шилдэг 50 хөгжимчдөөс бүрддэг. 1988 оноос хойш Винд Симфони Америкийн Нэгдсэн Улсаар хөндлөн гулд, мөн түүнчлэн БНХАУ, Тайвань, Хавай, Шинэ Зеланд, Австрали, Скандинавын орнуудаар аялан тоглосон. Шинэ Зеландын *North Eastern Telegraph* нэгэн сонинд “Хөгжимчдийн ямар ч алдаагүй, бүрэн мэдрэн тоглож байгаа нь амьсгал даран сонсох гайхашгийг

**Урлаг**  
Менежмент

Шуудангийн хайрцаг 28500 • Прово хот, Юта муж 84602-8500 • 801-422-3576 • Лавлах утас: 800-432-3576 •

Факс: 801-422-0546

Email: [perform@byu.edu](mailto:perform@byu.edu) • Интернет: <http://pam.byu.edu>

бүтээлээ.” гэж бичсэн байдаг.

Винд Симфони Монгол улсад анх удаа аялан тоглолт хийж байгаа ч тэдний хувьд Азид анх удаа аялан тоглож байгаа явдал биш юм. 2009 оны 5-р сард уг хамтлаг Өмнөд Солонгос, Японд анх удаа аялан тоглолтоо хийж байжээ. Энэ хоёр орноор олон газар аялан тоглох үед тэд Бусаны үлээвэр хөгжмийн оркестер зэрэг Зүүн Азид хамгийн алдартай үлээвэр хөгжмийн симфонуудтай хамтран тоглож байсан.

Тэдний хамгийн сүүлийн аялан тоглолт нь Нидерланд, Бельги, Франц, Герман зэрэг орнуудаар 2012 оны 4, 5 сард зохион байгуулагдсан. Тэд Герман улсын Фрейбергийн 850 жилийн <sup>ой</sup>, Нидерландын Хертонгенбош дахь Эрх чөлөөний ойн баярын тоглолтонд урилгаар оролцсон байдаг. "Далайн чанадаас барьсан гарнууд" нэртэй тоглолтыг Orkest Orventus-тай хамтран тайзнаа тоглосон. Зарим хотуудад үзэгчид хамтлагийг гурван удаа дахиулан тоглуулж байсан. Винд Симфони хамтлагийн тоглолтуудын мэргэжлийн чадвар нь Коллежийн хамтлагийн захирлуудын холбоо болон Америкийн хамтлагийн ахлагчдын холбоонд тоглолт хийх эрхэм хүндтэй урилгыг авахаар сонгогдох шалтгаан болсон юм. Энэхүү ансамбль Америкийн Урлагийг дэмжих үндэсний сангаас дэмжлэг авах санал хураалтаас маш их дэмлэгийг авсан билээ.

Винд Симфони нь Юта мужийн Прово хотын Бригама Янга их сургуулийн Дүрслэх урлаг харилцаа холбооны коллежийн Хөгжмийн сургуулиас гаралтай Бригама Янга их сургууль бол Америкийн Нэгдсэн Улс болон дэлхийн 120 улсаас 30,000 оюутан элсүүлдэг үндэсний хамгийн том хувийн их сургуулиудын нэг юм.

(төгсөв)

**Урлаг**  
**Менежмент**

Шуудангийн хайрцаг 28500 • Прово хот, Юта муж 84602-8500 • 801-422-3576 • Лавлах утас: 800-432-3576 •

Факс: 801-422-0546

Email: [perform@byu.edu](mailto:perform@byu.edu) • Интернет: <http://pam.byu.edu>